

Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол “Гамшгаас хамгаалах зарлан мэдээлэх дохио дамжуулах журам”-ын дагуу сумын хэмжээнд нийт 13 албан байгууллага, 2 багийн 847 иргэн, 56 авто машин оролцсон байна. Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу нүүлгэн шилжүүлэх ажилд 56 автомашины бэлэн байдлыг хангаж ажилласан.

2018 онд улс орон даяар зарласан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тохиолдуулан Шивээговь сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу 2018 оны 03 сарын 28-ны өдөр албан байгууллага, иргэдийн төлөөлөл 21 иргэнд “Газар хөдлөлтийн тухай ойлголт, серинн дохиогоор ажиллах заавар” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



2018 оны 03 сарын 29-ний өдөр Дуут дохиог ажиллуулах томилгоот холбоочин томилж, Дуут дохиог ажиллуулах журмыг танилцуулж, 30 сек-ын зайтай 1 минутын хугацаатай 3 удаа дугаргаж ажилласан.

- Серинн дохиог ЗДТГ-ын гадаа байрлуулах
- Аврах зам гарцын схемийг хийж ЗДТГ-ын 1, 2 давхаруудад байрлууллаа



Мөн Чанга яригчаар гудамж хорооллоор зарлаж ажилласан.

ДУУТ ДОХИОНД ХАМРАГДСАН ХҮН БОЛОН МАШИНЫ ТОО

№	Хамрагдсан байгууллагын нэр	Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан автомашины тоо
1	Засаг даргын Тамгын газар	14	-
2	Эрүүл мэндийн төв	29	1
3	3-р сургууль	15	-
4	3-р цэцэрлэг	243	1
5	Соёлын төв	2	-
6	Цагдаагийн хэсэг	2	1

7	ШОХК	205	10
8	Шивээ-Сервис ХХК	12	3
9	ХААН банк	4	-
10	Илчлэг-Шивээ ОНӨҮГазар	7	-
11	Холбоо	6	-
12	Ник ШТС	3	1
13	Сод монгол ШТС	6	3
14	1-р баг	207	24
15	2-р баг	92	12
	Нийт	847	56

Сургуулийн өмнөх боловсролын 220 хүүхэд хамрагдсан.

Дуут дохиогоор иргэд, албан хаагчид аюулгүйн 4 цэгт жагсаж, 3-р сургуулийн багш нар Говьсүмбэр аймагт багш нарын нэгдсэн зөвлөгөөнд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож байсан тул хамрагдсан албан хаагчдын тоо бага байна.





Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах, дуут дохиог ажиллуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу гамшгийн дараахь сэргээн босголтын ажилд иргэдийг дайчлан нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашаа хамгаалалтыг сайжруулж ажилласан.



Мэдээлсэн: ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал